



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАР
2022



УЛААНБААТАР ХОТ
2023 он

Танилцуулгыг боловсруулсан:

Э.Цэнд-Аюуш	ҮСХ-ны ЭЗСГ-ын МСҮСХ-ийн статистикч
Ч.Мөнхтуул	ҮСХ-ны ЭЗСГ-ын МСҮСХ-ийн статистикч

Танилцуулгыг хянасан:

М.Оюунжаргал	ҮСХ-ны ЭЗСГ-ын дарга
Л.Энхбаатар	ҮСХ-ны МСҮСХ-ийн дарга

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44

Засгийн газрын III байр

Утас: (976-11)-326414, 1900-1212

Факс: (976-11)-324518

Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn

И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
НЭР ТОМЬЁОНЫ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	8
БҮЛЭГ 1. ДОТООД ХУДАЛДАА.....	9
ДОТООД ХУДАЛДААНЫ САЛБАР	11
1.1 САЛБАРЫН ОНЦЛОГ	12
1.2 ХАМРАХ ХҮРЭЭ	12
1.3 НИЙТ БОРЛУУЛАЛТ	15
1.4 НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	16
1.5 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ	17
1.6 АЖИЛЛАГЧДЫН ТОО	18
1.7 АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН	20
1.8 ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ	22
БҮЛЭГ 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ.....	23
МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР	25
2.1 САЛБАРЫН ОНЦЛОГ	26
2.2 ХАМРАХ ХҮРЭЭ	27
2.3 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ	27
2.4 АЖИЛЛАГЧДЫН ТОО	27
2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК	28
2.6 ЖУУЛЧДЫН ТОО.....	30
2.7 ОЛОН УЛС ДАХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	33
БҮЛЭГ 3. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	35
ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН САЛБАР	36
3.1 САЛБАРЫН ОНЦЛОГ	37
3.3 ХАМРАХ ХҮРЭЭ	38
3.4 АЖИЛЛАГЧДЫН ТОО, САРЫН ДУНДАЖ ЦАЛИН	40
3.5 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ	42
3.6 ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	43
3.7 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	46
ДҮГНЭЛТ	48
ХАВСРАЛТ	50

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ЖИЛЭЭР.....	13
ХҮСНЭГТ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ДЭД САЛБАРААР.....	13
ХҮСНЭГТ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ 2022 ОНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДЭД САЛБАРААР.....	14
ХҮСНЭГТ 4. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, ТЭРБУМ ТӨГРӨГ	16
ХҮСНЭГТ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ОНЫ ҮНЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ ..	17
ХҮСНЭГТ 6. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ХЭМЖЭЭ, ОНЫ ҮНЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ	17
ХҮСНЭГТ 7. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, МЯНГАН ХҮН	18
ХҮСНЭГТ 8. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР	19
ХҮСНЭГТ 9. ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, МЯНГАН ТӨГРӨГ	21
ХҮСНЭГТ 10. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2015 ОНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР.....	22
ХҮСНЭГТ 11. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО	27
ХҮСНЭГТ 12. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ОНЫ ҮНЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ	27
ХҮСНЭГТ 13. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО	27
ХҮСНЭГТ 14. ГАДААДЫН ЖУУЛЧДААС ОЛСОН ОРЛОГО, ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, ТЭРБУМ ТӨГРӨГ	28
ХҮСНЭГТ 15. ГАДААДЫН НЭГ ЖУУЛЧИНД НОГДОХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО, ТЭРБУМ ТӨГРӨГ	29
ХҮСНЭГТ 16. ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, ЖУУЛЧДЫН ТОО, НЭГ ЖУУЛЧНЫ ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, ТЭРБУМ ТӨГРӨГ	29
ХҮСНЭГТ 17. УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ИРГЭД, ТӨРЛӨӨР, МЯНГАН ХҮН	30
ХҮСНЭГТ 18. УЛСЫН ХИЛЭЭР ГАРСАН МОНГОЛ ИРГЭД, ТӨРЛӨӨР, МЯНГАН ХҮН.....	32
ХҮСНЭГТ 19. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ИНДЕКС, ДЭД ИНДЕКС	33
ХҮСНЭГТ 20. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО	39
ХҮСНЭГТ 21. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, БҮСЭЭР	39
ХҮСНЭГТ 22. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР	40
ХҮСНЭГТ 23. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО	41
ХҮСНЭГТ 24. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ХЭМЖЭЭ, ОНЫ ҮНЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ	42
ХҮСНЭГТ 25. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, САЯ ТӨГРӨГ	43
ХҮСНЭГТ 26. ЗОЧИД БУУДЛЫН ЗЭРЭГЛЭЛ	43
ХҮСНЭГТ 27. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, ЗАРДАЛ, ЗОЧИД БУУДЛЫН ЗЭРЭГЛЭЛЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ	45

ХҮСНЭГТ 28. НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, ЗАРДАЛ, СУУДЛЫН ТОО	46
ХҮСНЭГТ 29. НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, ЗООГИЙН ГАЗРЫН ТӨРЛӨӨР, ТЭРБУМ ТӨГРӨГ	47

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР	15
ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, БУСАД САЛБАРТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, ИХНАЯД ТӨГРӨГ	16
ЗУРАГ 3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГ ДЭХҮҮН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, УЛИРЛААР, САЛБАРААР, ЭЗЛЭХ ХУВЬ	18
ЗУРАГ 4. НИЙТ АЖИЛЛАГЧИД БОЛОН ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСНААР, ХУВИАР	18
ЗУРАГ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР	19
ЗУРАГ 6. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛЭГ, БҮСЭЭР	20
ЗУРАГ 7. ХУДАЛДААНЫ ЦЭГ, УЛААНБААТАР, ТӨРЛӨӨР, 2022 ОН	20
ЗУРАГ 8. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ААНБ, АЖИЛЛАГЧДЫН ТОО	28
ЗУРАГ 9. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ДЭХ АЯЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ТЭРБУМ ТӨГРӨГ	29
ЗУРАГ 10. НЭГ ЖУУЛЧИНД НОГДОХ ОРЛОГО, ЗАРДАЛ, 2022 ОН.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
ЗУРАГ 11. ГАДААДЫН ЖУУЛЧДЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, АЯЛЛЫН ЗОРИЛГООР	31
ЗУРАГ 12. ГАДААДЫН ЖУУЛЧДЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ИРГЭНИЙ ХАРЬАЛЛААР	31
ЗУРАГ 13. ГАДААДАД 2022 ОНД ЗОРЧСОН МОНГОЛ ИРГЭДИЙН ТОО, ЗОРИЛГООР	32
ЗУРАГ 14. ОЛОН УЛСЫН ХҮЛЭЭН АВСАН ЖУУЛЧНЫ ТОО, САЯ ХҮН, ОНООР	34
ЗУРАГ 15. ДЭЛХИЙН ЗОЧИД БУУДАЛ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, ИХ НАЯД АМ.ДОЛЛАР	38
ЗУРАГ 16. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, БҮСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ	41
ЗУРАГ 17. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, МЯНГАН ТӨГРӨГ	42
ЗУРАГ 18. ЗОЧИД БУУДЛЫН ӨРӨӨНИЙ ТОО, БУУДЛЫН ТӨРЛӨӨР	44
ЗУРАГ 19. ЗОЧДЫН ТОО, МЯНГАН ХҮН, БУУСАН ХОНОГИЙН ТОО, НЭГ ЗОЧНЫ ДУНДАЖ БАЙРЛАХ ХУГАЦАА, ХОНОГООР	44
ЗУРАГ 20. ЗОЧИД БУУДЛЫН ОРЛОГО, АЙМГААР, ТЭРБУМ ТӨГРӨГ	45
ЗУРАГ 21. ЗОЧИД БУУДЛЫН ОРЛОГО, САРААР, ТЭРБУМ ТӨГРӨГ, ӨСӨЛТ БУУРАЛТ	46
ЗУРАГ 22. НЭГ ЗОЧИНД НОГДОХ ДУНДАЖ ОРЛОГО, ЗАРДАЛ, МЯНГАН ТӨГРӨГ	46
ЗУРАГ 23. ЗООГИЙН ГАЗРЫН ОРЛОГО, АЙМГААР, ТЭРБУМ ТӨГРӨГ	47
ЗУРАГ 24. ЗООГИЙН ГАЗРЫН ОРЛОГО, 2022 ОН, САРААР, ТЭРБУМ ТӨГРӨГ, ӨСӨЛТ БУУРАЛТ	48

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР	50
ХАВСРАЛТ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2022 ОНООР БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР.....	51
ХАВСРАЛТ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР, БҮТЦЭЭР	51
ХАВСРАЛТ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР, МЯНГАН ТӨГРӨГ	52

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗБ	Зочид буудал
НӨ	Нэмэгдэл өртөг
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
МХЗЭ	Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл
МҮЭ	Монголын Үйлдвэрчний Эвлэл
ТЗ	Төв Зөвлөл

ТЭМДЭГЛЭГЭЭ

* урьдчилсан гүйцэтгэл

Зочид буудлын өрөөний тоонд тухайн үйлчилгээний газрын байшин, барилгын зочид үйлчлүүлэгчдийг хоноход зориулсан өрөө тасалгааг хамруулна.

Бүлэг 1. ДОТООД ХУДАЛДАА





Аж ахуйн нэгж, байгууллагын тоо:



86 356

Үйл ажиллагаа явуулж
байгаа аж ахуйн нэгж,
байгууллага



33 028

Худалдааны чиглэлээр
үйл ажиллагаа явуулж
байгаа



17 982

Бөөний худалдаа
эрхэлдэг



15 046

Жижиглэн худалдаа
эрхэлдэг

Ажиллагчдын тоо:



146.2 мянган хүн
ХУДАЛДААНЫ САЛБАРТ
АЖИЛЛАГЧДЫН ТОО

Нийт борлуулалт, үйлдвэрлэл:

Тэрбум төгрөг



42 457.2

НИЙТ БОРЛУУЛАЛТ

8 935.0

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ



ДОТООД ХУДАЛДААНЫ САЛБАР

Монгол Улсын худалдааны салбар нь улс ардын аж ахуйн ууган салбаруудын нэг тул бүртгэл мэдээлэл нь тэр хэмжээгээр түлхүү хөгжиж ирсэн. Монгол Улсын Сангийн Яамнаас Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын зохих байгууллагуудтай худалдааны хэлэлцээрийг 1921 оны 5 сард, мөн түүнчлэн Монгол-Зөвлөлтийн Засгийн газрын хооронд худалдааны хэлэлцээрийг 1923 онд байгуулсан. Энэ үеэс эхлэн манай улсын худалдааны салбарт бүртгэл данс хөтлөгдөж, мэдээ тайлан гаргах болсон байна. Ялангуяа Зөвлөлтийн худалдааны тоо бүртгэл нэвтэрч, зөвлөлтийн мэргэжилтэн энэ ажилд биечлэн тусалж, худалдааны салбарын тоо бүртгэл, мэдээ, тайланг үүсгэн бий болгожээ. Гаалийн бүртгэл 1921-1924 онд хөтлөгдөж эхэлсэн байна.



Ардын харилцан туслалцах хоршоо 1921 оны 12 дугаар сард байгуулагдаж, тэнд данс бүртгэлийг үнэн зөв хөтлөх талаар ихээхэн анхаарч байжээ.

Худалдааны бүртгэлийн үндсэн үзүүлэлтүүд нь 1930-аад он хүртэл хүн амд худалдсан бараа, хоршооны гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, цэг, салбарын тоо, бэлтгэлийн зүйлийн тоо хэмжээ, хувийн худалдаачдын тоо,

тэднээс улсад төлсөн албан татвар, экспорт, импортын нийт хэмжээ зэрэг цөөн тооны үзүүлэлтийг нягтлан бодох бүртгэлийн тайланд тусган нэгтгэдэг байжээ.

Монголын төв хоршооны үйлдвэрлэлийн хоршооллын хэлтсийн суурь дээр 1931 онд Монголын гар үйлдвэрийн холбоо байгуулагдсанаар үйлдвэрийн хоршоолол, эд хэрэглэгчдийн хоршоолол гэсэн хоёр салбартай болсон нь бүртгэл мэдээллийн үзүүлэлтийн хүрээг өргөжүүлсэн байна.

Улсын худалдааны газрыг 1934 онд байгуулсан байна. 1940-өөд оны эхээр аж үйлдвэрийн газруудын харьяанд жижиглэнгийн худалдааны газруудыг бий болгосноор улсын худалдаа өргөжиж, гүйлгээний хүрээнд улс, хоршооллын худалдааны хувийн жин зонхилох болжээ. Тэр үед Эд хэрэглэгчдийн төв холбооноос худалдаа бэлтгэлийн сар, улирлын мэдээний маягт, зааврыг боловсруулан мөрдүүлж байсныг худалдааны мэдээллийн системийн үүсэл гэж үзэж болно.

Жижиглэнгийн нийт бараа гүйлгээг 1930 оноос эхлэн өмчийн хэлбэрээр тооцож байжээ.

Жижиглэн худалдааны бараа гүйлгээг 1940 оноос эхлэн худалдааны төрлөөр гаргаж эхэлсэн бол 1950 оноос эхлэн жижиглэн худалдаалах бараа гүйлгээг барааны бүлэг, бараа үйлдвэрлэлтийн гарлаар нь ангилан мэдээлж байв. Улс, хоршооллын худалдааны бүх газарт Улсын төлөвлөгөөний комиссын батлагдсан нэг хэвийн маягтаар 1950-иад оны эхнээс мэдээ гаргадаг журмыг тогтоож, нэвтрүүлсэн байна.

Худалдааны салбарын бүртгэл, мэдээг хөдөө аж ахуйн нэгдлийн худалдаанд 1960 оноос эхлэн хамааруулж, хүрээг өргөжүүлжээ.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр худалдааны салбарын статистикийн үзүүлэлт, аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай болсон. Худалдааны статистикийн мэдээлэл нь олон улсын статистикийн үзүүлэлтийн тогтолцоотой уялдуулах шаардлагад нийцэж, өөрчлөгдөн хөгжсөөр байна.

1.1 САЛБАРЫН ОНЦЛОГ

1.2 XAMPAX XYPЭЭ

Албан секторын хамрах хүрээ нь бизнес регистрийн санд бүртгэлтэй бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт болно. Албан бус секторын үйл ажиллагаанд албан ёсоор аж ахуйн нэгж, байгууллага гэж бүртгэгдээгүй, хувиараа худалдаа эрхлэгчдийг оруулж байна. Эдгээрт лангуу, чингэлгийн худалдаа, түргэн үйлчилгээний цэгүүд, гутал засвар, авто засварын үйл ажиллагаа орно.

Бизнес регистрийн санд 2022 оны эцсийн байдлаар бүртгэлтэй 86.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 33.0 (38.2%) мянган аж ахуйн нэгж нь худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, жилээр

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
БҮГД	71 717	75 522	76 329	81 533	86 356
Худалдааны салбарын ААНБ-ын тоо	25 859	27 396	28 076	29 672	33 028
Худалдааны салбарын ААНБ-ын эзлэх хувь	36.1	36.3	36.8	36.4	38.2

Улсын хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2022 онд 33.0 мянга болж, өмнөх оноос 3.4 (11.3%) мянгаар өслөө.

ХҮСНЭГТ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар

Салбар	2018	2019	2020	2021	2022*
БҮГД	25 859	27 396	28 076	29 672	33 028
Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	1 165	1 194	1 387	1 627	1 886
Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны бөөний худалдаа	14 692	15 864	15 708	16 201	17 982
Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдаа	10 002	10 338	10 981	11 844	13 160

Худалдааны салбарт 2022 онд үйл ажиллагаа явуулж байгаа 33.0 мянган ААНБ байгаагийн 1.9 (5.7%) мянга нь Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний чиглэлээр, 18.0 (54.4%) мянга нь Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны бөөний худалдааны чиглэлээр, 13.1 (39.9%) мянга нь Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2022 онд өмнөх оноос 259 (15.9%), Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1781 (11.0%), Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1316 (11.1%) тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ 2022 ОНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, дэд салбараар

Бүс, аймаг, нийслэл	БҮГД	Үүнээс:		
		Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны бөөний худалдаа	Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдаа
Бүгд	33 028	1 886	17 982	13 160
Баруун бүс	2 308	66	596	1 646
Баян-Өлгий	361	17	157	187
Говь-Алтай	295	9	54	232
Завхан	475	7	177	291
Увс	548	16	75	457
Ховд	629	17	133	479
Хангайн бүс	2 419	100	724	1 595
Архангай	268	11	57	200
Баянхонгор	266	10	57	199
Булган	300	10	48	242
Орхон	905	42	388	475
Өвөрхангай	304	10	81	213
Хөвсгөл	376	17	93	266
Төвийн бүс	2 874	144	900	1 830
Говьсүмбэр	91	6	21	64
Дархан-Уул	761	38	216	507
Дорноговь	341	16	90	235
Дундговь	216	4	47	165
Өмнөговь	724	55	285	384
Сэлэнгэ	555	14	171	370
Төв	186	11	70	105
Зүүн бүс	1 132	43	213	876
Дорнод	502	30	137	335
Сүхбаатар	286	4	41	241
Хэнтий	344	9	35	300
Улаанбаатар	24 295	1 533	15 549	7 213

Улсын хэмжээнд 2022 онд моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээ эрхэлдэг 1886 аж ахуйн нэгж, байгууллагын 66 (3.5%) нь Баруун бүсэд, 100 (5.3%) нь Хангайн бүсэд, 144 (7.6%) нь Төвийн бүсэд, 43 (2.3%) нь Зүүн бүсэд, 1533 (81.3%) нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад бөөний худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа 18.0 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 596 (3.3%) нь Баруун бүсэд, 724 (4.0%) нь Хангайн бүсэд, 900 (5.0%) нь Төвийн бүсэд, 213 (1.2%) нь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 15.5 (86.5%) мянга нь тус тус байна.

Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа 13.1 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 1.6 (12.5%) мянга нь

Худалдааны салбарын үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 2.3 (7.0%) мянга нь Баруун бүсэд, 2.4 (7.3%) мянга нь Хангайн бүсэд, 2.9 (8.7%) мянга нь Төвийн бүсэд, 1.1 (3.4%) мянга нь Зүүн бүсэд, 24.3 (73.6%) мянга нь Улаанбаатар хотод ногдож байна.

Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага

1-199
200-399
400-599
600-799
800-999
20000 дээш

Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Ховд, Завхан, Архангай, Улаанбаатар, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Говьсүмбэр, Сүхбаатар, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Баян-Өлгий

1.3 НИЙТ БОРЛУУЛАЛТ

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2022 онд 42.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 10.1 (31.2%) их наяд төгрөгөөр өслөө.


ХҮСНЭГТ 4. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөг

Он	Нийт борлуулалт	Үүнээс:		Дүнд эзлэх хувь	Үүнээс:	
		Албан сектор	Албан бус сектор		Албан сектор	Албан бус сектор
2018	24 133.8	21 275.1	2 858.7	100.0	88.2	11.8
2019	27 076.8	24 220.8	2 856.0	100.0	89.5	10.5
2020	25 480.0	22 244.6	3 235.4	100.0	87.3	12.7
2021	32 355.7	28 498.9	3 856.8	100.0	88.1	11.9
2022	42 457.2	38 088.8	4 368.4	100.0	89.7	10.3

Албан секторын нийт борлуулалт 2022 онд 38.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 9.6 (33.7%) их наяд төгрөгөөр, албан бус секторын нийт борлуулалт 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 511.6 (13.3%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Нийт борлуулалтад албан секторын орлого 89.7 хувь, албан бус секторын орлого 10.3 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, бусад салбартай харьцуулсан байдал, их наяд төгрөг



Эх үүсвэр: Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

1.4 НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

Худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийг бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-ын нийлбэрээр тооцдог.

ХҮСНЭГТ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, оны үнээр, тэрбум төгрөг

Тайлбар: Бүтээгдэхүүний цэвэр татвар орсон дүнгээр


1.5 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ

Дотоод худалдааны салбар нь манай орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг үйлчилгээний салбарын нэг бөгөөд 2022 онд ДНБ-ий 10.5 хувийг эзэлж байна.

Тайлбар: Бүтээгдэхүүний цэвэр татвар орсон дүнгээр

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2022 онд оны үнээр 5.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.6 (39.5%) ихнаяд төгрөгөөр өссөн байна. Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2018 оноос 2.6 (83.7%) ихнаяд төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, салбараар, эзлэх хувь



1.6 АЖИЛЛАГЧДЫН ТОО

Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр суурь эзэлдэг үйлчилгээний салбарын нэг юм. Улсын хэмжээнд худалдааны салбарт 2022 онд 146.2 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 12.4 хувийг эзэлж байна.


ХҮСНЭГТ 7. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, мянган хүн

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Нийт ажиллагчид	1 253.0	1 146.2	1 162.9	1 125.6	1 180.5
Худалдааны салбарт	211.2	160.4	166.6	149.2	146.2
Худалдааны салбарын эзлэх хувь	16.9	14.0	14.3	13.3	12.4

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Худалдааны салбарын ажиллагчдын тоо 2022 онд өмнөх оноос 2.9 (2.0%) мянгаар буурсан байна. Худалдааны салбарт ажиллагчдын 61.8 (42.3%) мянга нь эрэгтэй, 84.4 (57.7%) мянга нь эмэгтэй ажиллагчид байна.

ЗУРАГ 4. НИЙТ АЖИЛЛАГЧИД БОЛОН ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх онтой харьцуулснаар, хувиар



Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа


ХҮСНЭГТ 8. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	211 187	160 405	166 590	149 168	146 236
Баруун бүс	23 180	11 319	18 431	16 128	11 796
Баян-Өлгий	7 366	3 511	4 502	4 869	4 737
Говь-Алтай	3 134	662	1 763	1 204	725
Завхан	3 052	2 710	1 693	2 606	1 120
Увс	4 206	911	3 863	2 932	2 393
Ховд	5 422	3 524	6 610	4 517	2 821
Хангайн бүс	26 532	26 178	22 846	15 468	19 198
Архангай	3 416	5 419	6 790	2 881	1 768
Баянхонгор	4 675	3 701	1 852	3 384	1 483
Булган	1 413	1 564	798	886	1 226
Өвөрхангай	6 359	3 687	3 839	3 441	5 708
Хөвсгөл	3 976	6 413	4 666	325	5 381
Орхон	6 692	5 396	4 901	4 551	3 632
Төвийн бүс	31 660	21 556	16 580	14 412	14 696
Дорноговь	4 164	4 991	3 042	3 276	3 093
Дундговь	2 693	1 311	1 264	854	1 531
Өмнөговь	3 789	3 045	1 415	2 971	1 948
Сэлэнгэ	6 391	3 281	1 930	1 384	1 749
Төв	6 272	2 366	1 606	772	1 666
Дархан-Уул	7 054	5 789	6 882	4 437	4 447
Говьсүмбэр	1 296	772	441	717	263
Зүүн бүс	10 470	8 937	5 304	6 881	6 785
Дорнод	3 087	4 625	1 497	3 234	3 116
Сүхбаатар	3 864	2 247	2 294	1 796	1 961
Хэнтий	3 520	2 065	1 513	1 851	1 709
Улаанбаатар	119 344	92 415	103 429	96 279	93 761


Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Худалдааны салбарын ажиллагчид 2022 онд 146.2 мянга байгаагаас Баруун бүсэд 11.8 (8.1%) мянга, Хангайн бүсэд 19.2 (13.1%) мянга, Төвийн бүсэд 14.7 (10.0%) мянга, Зүүн бүсэд 6.8 (4.7%) мянга, Улаанбаатар хотод 93.7 (64.1%) мянга байна.


ЗУРАГ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ажиллагчдын тооны бүлгээр



ЗУРАГ 6. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, дүнд эзлэх хувь, ажиллагчдын тооны бүлэг, бүсээр



ЗУРАГ 7. ХУДАЛДААНЫ ЦЭГ, хотод, төрлөөр, 2022 он



Эх үүсвэр: Захиргааны статистикийн мэдээллийн маягт БР-3 худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэгийн судалгаа

1.7 АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаар 2022 онд 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 224.4 (17.5%) мянган төгрөгөөр өссөн бол, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчдын дундаж цалин 1.3 сая төгрөг болж, өмнөх оноос 194.3 (18.3%) мянган төгрөгөөр өссөн байна.

Аймаг, нийслэл	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	818.6	904.8	1 001.7	1 063.1	1 257.4
Баруун бүс	436.0	517.6	603.8	634.3	712.3
Баян-Өлгий	396.7	464.1	558.9	586.5	658.8
Говь-Алтай	499.6	592.0	668.6	717.0	818.4
Завхан	424.4	489.7	555.3	568.3	627.5
Увс	422.1	515.3	597.4	625.6	692.8
Ховд	442.9	522.8	619.7	659.8	739.4
Хангайн бүс	464.8	552.9	646.7	676.0	768.8
Архангай	373.9	459.4	541.3	615.0	628.0
Баянхонгор	459.6	536.9	618.5	631.8	715.7
Булган	368.2	470.7	556.8	577.0	605.3
Орхон	524.7	619.8	708.5	739.8	857.4
Өвөрхангай	483.2	572.6	674.0	723.0	818.4
Хөвсгөл	410.6	483.7	588.2	604.9	687.7
Төвийн бүс	604.3	697.0	834.1	942.2	1 435.0
Говьсүмбэр	594.6	686.9	775.1	818.4	981.7
Дархан-Уул	562.6	649.7	478.2	797.7	962.0
Дорноговь	747.1	825.6	921.4	917.6	1 248.8
Дундговь	395.3	471.8	564.4	579.0	659.1
Өмнөговь	726.6	842.4	1 068.5	1 314.4	2 301.1
Сэлэнгэ	430.5	518.5	600.0	633.9	708.3
Төв	538.5	611.0	687.7	756.4	883.2
Зүүн бүс	416.0	498.3	586.5	638.4	697.3
Дорнод	446.9	533.3	616.8	657.6	745.7
Сүхбаатар	373.6	449.7	536.9	566.9	594.6
Хэнтий	399.0	487.3	579.9	661.1	695.3
Улаанбаатар	890.1	973.4	1 066.5	1 126.0	1 299.1

Худалдааны салбарын ажиллагчдын сарын дундаж цалин баруун бүсэд 712.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 78.0 (12.3%) мянган төгрөгөөр, хангайн бүсэд 768.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 92.9 (13.7%) мянган төгрөгөөр, зүүн бүсэд 697.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 58.9 (9.2%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 1.4 сая төгрөг болж, өмнөх оноос 492.8 (52.3%) сая төгрөгөөр тус тус өсжээ.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын ажиллагчдын цалин нь Улаанбаатар, Өмнөговь, Дорноговь аймгуудад улсын дундажаас өндөр харин бусад аймгуудад бага байна.

1.8 ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

Нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг буюу худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж 2022 онд 2015 оны зэрэгцүүлэх үнээр 38.8 сая төгрөг болж, өмнөх оноос 11.5 (42.1%) сая төгрөгөөр өссөн байна. Харин 2018 оноос 24.2 (2.7 дахин) сая төгрөгөөр өсжээ.

ХҮСНЭГТ 10. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, оны үнээр

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Хөдөлмөрийн бүтээмж, сая төгрөг	14.6	22.7	20.6	27.3	38.8
Нэмэгдэл өртөг, тэрбум төгрөг	3 090.2	3 644.1	3 436.8	4 069.6	5 677.9
Ажиллагчид, мянган хүн	211.2	160.4	166.6	149.2	146.2

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Бүлэг 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ





Аж ахуйн нэгж, байгууллагын тоо



86 356

Үйл ажиллагаа
явуулж байгаа аж
ахуйн нэгж,
байгууллага



1 267

Аялал жуулчлалын
чиглэлээр үйл ажиллагаа
явуулж байгаа



1.6

мянган хүн

АЖИЛЛАГЧДЫН ТОО

286 282

УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН
ЖУУЛЧИД, УЛСААР



11 186

БНХАУ



153 162

ОХУ



53 382

БНСУ



68 552

Бусад

988 595

УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН
ГАДААДЫН ИРГЭД



27 550

Албан ажлаар



121 936

Хувийн журмаар



122 930

Жуулчлал



6 671

Ажиллах



5 492

Дамжиж өнгөрөх



1 677

суралцах



693 965

Байнга оршин суух



8 374

бусад

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР



Монголын аялал жуулчлалын суурь хөгжлийн үеийг 1954-1990 он гэж тодорхойлдог ба энэ салбар нь манай улсын хувьд харьцангуй шинэ, залуу салбар юм. 1954 онд одоогийн Жуулчин компани нь Гадаад Худалдааны Яам /хуучнаар/-ны дэргэд “Гадаадын жуулчдад үйлчлэх товчоо” нэртэйгээр байгуулагдаж, анчин, жуулчид болон, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын групп жуулчдад үйлчлэх болсноор Монгол оронд аялал жуулчлал хөгжих эх үүсвэр тавигджээ.

Эл товчоог байгуулж байх үед 60 хүн хүлээн авах хүчин чадалтай “Алтай” зочид буудал болон ресторан, 21 автомашин бүхий бааз бий болж, захиргаа ба үйлчилгээний ажилтнуудыг хамруулан нийт 107 хүний орон тоотой байжээ. 1956 оны 7 дугаар сард ЗХУ-ын 15 жуулчинг 9 хоног аялуулахаар хүлээн авсан нь анхны зохион байгуулалттай аялал байв. Мөн оны 10 дугаар сард Прага хотноо болсон “Социалист орнуудын жуулчдын байгууллагын анхдугаар бага хурал”-д Монголын төлөөлөгчид оролцсон төдийгүй 10 орчим оронтой жуулчин хүлээн авах гэрээг байгуулсан байна.

1962 онд АНУ-ын “Космос трэвэл” компаний ерөнхийлөгч Гаврил Рейнер тэргүүтэй жуулчид Монголд ирснээр гуравдагч оронтой жуулчны асуудлаар харилцах эхлэл тавигджээ.

1962 онд Тэрэлжид, 1964, 1968 онд Өмнөговь аймагт анхны жуулчны баазуудыг байгуулжээ. Тухайн үеийн аяллын чиглэлд Улаанбаатар хот, Ёлын-Ам, Хонгорын элс, Орхоны цутгалан, Хужирт, Хархорин, Тэрэлж, Сонгино, Сөгнөгөр хэмээх газрууд хамаардаг байв.

1975 онд МХЗЭ-ийн дэргэд “Залуу аялагчдын товчоо”, 1976 онд МҮЭ-ийн ТЗ-ийн дэргэд “Аялал жуулчлалын товчоо” тус тус байгуулагджээ. 1976 онд 3681 анчин, жуулчин хүлээн авсан бол 1989 онд 10291 анчин, жуулчин хүлээн авч үйлчилсэн нь тухайн үеийн хамгийн өндөр үзүүлэлт байжээ.

1991 онд Монгол Улс Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын гишүүн орон болсон байна. 1990 онд “Гадаадын жуулчдыг үйлчлэх газар”-ыг бие даасан “Жуулчин” нэгтгэл болгож, 1991 онд Өмч хувьчлалын комиссын шийдвэрээр “Жуулчин” хувьцаат компани болгон өөрчилсөн байна. 1995 онд Засгийн газрын тогтоолоор “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж, Худалдаа Үйлдвэрийн Яаманд аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны нэгжийг бий болгожээ.

1998 онд Засгийн газрын тогтоолоор “Аялал жуулчлалын бодлого зохицуулах Үндэсний Зөвлөл”-ийг байгуулж, дүрмийг баталсан. 1999 онд Засгийн газрын 214 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Аялал жуулчлалын газар”-ыг байгуулж, улмаар 2004 онд татан буулгаж, шинээр байгуулагдсан Зам Тээвэр, Аялал Жуулчлалын Яамны бүтцэд нэгтгэсэн юм. 2008 оноос Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам болон өөрчлөгджээ.

1999 онд Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”, 2000 онд УИХ-аас “Аялал жуулчлалын хууль”-ийг батлан гаргаж эрхзүйн орчинг бүрдүүлж эхэлсэн.

2003 онд “Монголд зочлох жил”, 2004 онд “Монголыг нээх жил”, 2006 онд “Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн жил” болгон тус тус зарлаж, монголыг гадаадад сурталчлах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх, Монгол орны түүх дурсгалын зүйлсийг хамгаалах чиглэлээр бодитой ажлууд хийгджээ.

Эдүгээ Монгол улсад ирж буй жуулчдын 92 хувийг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, Их Британи, Казахстан, Австрали зэрэг орны жуулчид бүрдүүлдэг.

Монгол бол аялал жуулчлалын хувьд аюулгүй орон: Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас Монгол улсыг аялал жуулчлалын нөөцөөр “үнэ цэнэтэйд орох газар” хэмээн дүгнэж, Монгол орныг жуулчдад аюулгүй, найдвартай орны тоонд оруулан зарлажээ.

2.1 САЛБАРЫН ОНЦЛОГ

Аялал жуулчлалын салбар нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны үйл ажиллагаа хосолсон шинж чанараараа бусад эдийн засгийн салбараас онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, аялал жуулчлалын салбар нь байгалийн тогтоц, өгөгдөл, тухайн улсын соёлын өв, ёс заншил, онцлог уламжлалын нөөц дээр тулгуурласан, эдгээр өв соёлыг устаж үгүй болохоос хамгаалсан, эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн бодлого хэрэгжих хамгийн боломжит салбар юм.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) хамгийн сүүлийн мэдээллээр олон улсын жуулчдын тоо 2 дахин өссөн байна. Дэлхийн улс орнууд 2022 онд өмнөх оныхоос 507.0 (2.1 дахин) саяаар олон гадаадын иргэдийг хүлээж авсан байна.

Байнгын оршин суугаа газраас 183 хоног буюу 6 сар хүртэл хугацаагаар өөр газарт байрлаж байгаа хүнийг Монгол Улсад жуулчин гэж үзэх ба үүнтэй холбогдох эдийн засгийн үйл ажиллагааг аялал жуулчлалын салбарт авч үздэг. Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдыг зорилгоор нь албан, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот, аймгийн төвүүдийг холбосон хатуу хучилттай замууд шинээр ашиглалтад орсон нь аялал жуулчлалын хөгжилд ихээхэн хөшүүрэг болж байна.

Аялал жуулчлалын салбарт дараах үйл ажиллагааг авч үзнэ. Үүнд:

- ✓ Олон нийт болон худалдааны үйлчлүүлэгчдэд үзүүлэх аялал, жуулчлал, тээвэрлэлт, байр сууцаар хангах үйл ажиллагааны борлуулалтыг голлон эрхэлдэг агентлагийн үйл ажиллагаа;
- ✓ Аялал жуулчлалын агентлаг эсвэл аяллын оператор зэрэг шууд агентаар дамжуулан хийгдэх аяллыг зохицуулах үйл ажиллагаа;
- ✓ Жуулчлалтай холбоотой захиалгат үйлчилгээ;
- ✓ Аяллын хөтөчийн үйл ажиллагаа энд багтана.

7911 – Аялал жуулчлалын агентлагийн үйл ажиллагаа;
7912 – Аяллын операторын үйл ажиллагаа;
7990 – Захиалгаар хийгдэх үйлчилгээ болон түүний туслах үйлчилгээ.

Бизнес регистрийн санд 2022 оны эцсийн байдлаар бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 86.4 мянган ААНБ-аас 1.3 (1.5%) мянга нь аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна.

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
БҮГД	71 716	75 522	76 329	81 533	86 356
Аялал жуулчлалын салбарын ААНБ-ын тоо	1 191	1 281	1 101	1 117	1 267
Аялал жуулчлалын салбарын ААНБ-ын эзлэх хувь	1.7	1.7	1.4	1.4	1.5

2.3 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ

ХҮСНЭГТ 12. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, оны үнээр, тэрбум төгрөг


Тайлбар: Бүтээгдэхүүний цэвэр татвар орсон дүнгээр

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын ажиллагчдын тоо 2022 онд 1.6 мянга болж, өмнөх оноос 0.7 (29.4%) мянгаар бүүрсан байна.

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Ажиллагчдын тоо	5 694	6 832	4 421	2 303	1 627
Аялал жуулчлалын салбарын ААНБ-ын тоо	1 191	1 281	1 101	1 117	1 267
Нэг ААНБ-д ногдох ажиллагчдын тоо	4.8	5.3	4.0	2.1	1.3

Аялал жуулчлалын салбарын нэг аж ахуйн нэгж, байгууллагад 2022 онд 1.3 ажиллагч ногдож байна.

ЗУРАГ 8. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ААНБ, АЖИЛЛАГЧДЫН ТОО



2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Гадаадын жуулчдаас олсон орлого 2022 онд 803.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 745.2 (12.7 дахин) тэрбум төгрөгөөр, дотоодын жуулчдын гадаадад аялсан зардал 2022 онд 3148.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1034.0 (48.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 14. ГАДААДЫН ЖУУЛЧДААС ОЛСОН ОРЛОГО, ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, тэрбум төгрөг


Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Гадаад жуулчдаас олсон орлого	1 098.1	1 367.3	81.5	58.5	803.7
Дотоодын жуулчдын гадаадад аялсан зардал	2 128.2	2 465.4	1 540.0	2 114.7	3 148.7
Тэнцэл	-1 029.4	-1 098.1	-1 458.5	-2 056.2	-2 345.0

Эх үүсвэр: Монголбанк, Төлбөрийн тэнцэл

Тайлбар: Төлбөрийн тэнцлийн урсгал дансны аялал жуулчлалын үйлчилгээнээс бусад (1.А.б.4.2.3) буюу аялал, жуулчлал, найз нөхөд, хамаатан садныдаа зочлох болон мөргөл хийх, шашны зан үйлийн ажиллагаанд оролцох зэрэг амралт зугаалгын үйл ажиллагаатай холбоотой жуулчдаас олсон орлого, зардлын дүнг авсан болно.

Төлбөрийн тэнцлийн статистикаас харахад гадаадын жуулчдаас олсон орлого, дотоодын жуулчдын гадаадад аялсан зардлын зөрүү алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ 2022 онд 2345.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 288.8 (14.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 9. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ДЭХ АЯЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, тэрбум төгрөг



Эх үүсвэр: Монголбанк, төлбөрийн тэнцэл,

ХҮСНЭГТ 15. ГАДААДЫН НЭГ ЖУУЛЧИНД НОГДОХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Гадаадын жуулчдаас олсон орлого	1 098.7	1 367.3	81.5	58.5	803.7
Монгол Улсад аялсан гадаадын жуулчдын тоо ¹	260 991	303 169	11 169	3 701	141 164
Нэг жуулчинд ногдох орлого	4.2	4.5	7.3	15.8	5.7

Эх үүсвэр: Монголбанк, Төлбөрийн тэнцэл,

¹Жуулчдын тоог Монголбанкнаас судалгаанд үндэслэн тооцсон дүнгээр авсан.

ХҮСНЭГТ 16. ДОТООДЫН ЖУУЛЧДЫН ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, ЖУУЛЧДЫН ТОО, НЭГ ЖУУЛЧНЫ ГАДААДАД АЯЛСАН ЗАРДАЛ, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Дотоодын жуулчдын гадаадад аялсан зардал	2 128.2	2 465.4	1 540.0	2 114.7	3 148.7
Гадаад улсад аялсан Монгол жуулчдын тоо ¹	281 655	311 529	42 439	28 805	162 838
Нэг жуулчинд ногдох зардал	7.6	7.9	36.3	73.4	19.3

Эх үүсвэр: Монголбанк, Төлбөрийн тэнцэл,

¹Жуулчдын тоог Монголбанкнаас судалгаанд үндэслэн тооцсон дүнгээр авсан.

2022 онд гадаадын нэг жуулчнаас 5.7 сая төгрөгийг орлого олсон бол өнгөрсөн онтой харьцуулахад 2.8 дахин, нэг дотоод жуулчин гадаадад аялахдаа 19.3 сая төгрөгийн зардал гаргасан бол өнгөрсөн онтой харьцуулахад 3.8 дахин тус тус буурсан байна.

2.6 ЖУУЛЧДЫН ТОО

Монгол Улсад ирж буй гадаад иргэдийг аяллын зорилгоор нь албан ажлаар, хувийн журмаар, жуулчлал, ажиллах, суралцах, дамжин өнгөрөх мөн байнга оршин суух гэж ангилан бүртгэдэг. Эдгээрээс байнга оршин суух, ажиллах, суралцахаас бусад зорилгоор ирсэн гадаадын иргэдийг гадаад жуулчин гэж тодорхойлдог.

ХҮСНЭГТ 17. УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ИРГЭД, төрлөөр, мянган хүн

Он	Улсын хилээр орсон гадаадын иргэд	Үүнээс:								
		Ажиллах	Суралцах	Байнга оршин суух	Улсын хилээр орсон жуулчдын тоо	Үүнээс:				
						Албан	Хувийн	Жуулчлал	Дамжин	Бусад
2018	598.7	54.7	4.8	9.9	529.4	54.4	204.6	222.2	3.9	44.4
2019	637.0	41.4	6.5	11.8	577.3	52.7	207.9	260.1	8.8	47.9
2020	66.9	5.6	0.5	2.0	58.9	19.7	28.0	7.8	0.3	3.0
2021	39.2	4.5	0.5	1.1	33.1	10.9	18.3	1.0	0.1	2.8
2022	988.6	6.7	1.8	694.0	286.1	27.5	121.9	122.9	5.5	8.3

Тайлбар: Жуулчин гэж байнга оршин суудаг газраас өөр газарт ажил эрхлэн, цалин, хөлс авахаас бусад зорилгоор 1 хоногоос дээш 183 хоног хүртэлх хугацаагаар аялж буй хүн буюу ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоос бусад зорилгоор хилээр нэвтэрсэн зорчигчийг авч үзнэ.


Эх үүсвэр: Хил хамгаалах ерөнхий газар

Монгол Улсыг зорин ирсэн жуулчдын тоо 2022 онд 286.1 мянга болж, өмнөх оноос 253 (8.6 дахин) мянган жуулчнаар өсч, 2018 оноос 243.3 (45.9%) мянган жуулчнаар буурсан байна.

Хувийн зорилгоор ирж буй аялагчдын тоо 2022 онд 121.9 мянга болж, өмнөх оноос 103.6 (6.7 дахин) мянгаар өсч, 2018 оноос 83.0 (40%) мянгаар буурсан байна. Аялах /жуулчлал/ зорилгоор ирж байгаа хүний тоо 2022 онд 122.9 мянга болж, өмнөх оноос 121.9 (12.3 дахин) мянгаар өсч, 2018 оноос 99.0 (44.7%) мянгаар буурсан байна.


Манай улсад 2018 онд албан ажлын зорилгоор ирсэн жуулчдын тоо 54.4 мянга, хувийн зорилгоор 204.6 мянга, жуулчилж ирсэн 222.2 мянга, дамжин өнгөрөх зорилгоор 3.9 мянга, бусад зорилгоор 44.4 мянга ирсэн байсан бол 2022 онд албаны зорилгоор 27.5 мянга болж, 2018 оноос 49.4 хувиар, хувийн зорилгоор 121.9 мянга болж, 2018 оноос 40.4 хувиар, аялах буюу жуулчлах зорилгоор 122.9 мянга болж, 2018 оноос 44.7 хувиар, бусад зорилгоор 8.3 мянга болж, 2018 оноос 81.3 хувиар тус тус буурсан байна. Харин дамжин өнгөрөх зорилгоор 5.5 мянга болж, 2018 оноос 41.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ТОО, дүнд эзлэх хувиар, аяллын зорилгоор



Монгол Улсад 2022 онд ирсэн жуулчдын 43.0 хувь нь жуулчлал, 42.6 хувь нь хувийн зорилгоор, 9.6 хувь нь албаны зорилгоор, 2.9 хувь нь бусад зорилгоор, 1.9 хувь нь дамжих өнгөрөх зорилгоор иржээ. Жуулчдын 53.5 хувийг ОХУ-ын иргэд, 24.0 хувийг бусад улсын иргэд, 18.6 хувийг БНСУ-ын иргэд, 3.9 хувийг БНХАУ-ын иргэд эзэлж байна.

ЗУРАГ 11. ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ТОО, дүнд эзлэх хувиар, иргэний харьяаллаар



Гадаадад зорчсон Монгол жуулчдын тоо 2022 онд 429.3 мянга болж, өмнөх оноос 308.2 (3.5 дахин) мянган жуулчин, 2018 оноос 1.5 (4.6 дахин) сая жуулчнаар тус тус буурсан байна.

Хувийн зорилгоор зорчиж буй Монгол аялагчдын тоо 2022 онд 267.8 мянга болж, өмнөх оноос 187.7 (3.3 дахин) мянгаар өсч, 2018 оноос 1.5 (84.9%) саяаар буурсан байна. Аялах /жуулчлал/ зорилгоор явж байгаа хүний тоо 2022 онд 83.8 мянга болж, өмнөх оноос 76.7 (11.8 дахин) мянгаар өсч, 2018 оноос 47.7 (36.3%) мянгаар буурчээ.

ХҮСНЭГТ 18. УЛСЫН ХИЛЭЭР ГАРСАН МОНГОЛ ИРГЭД, төрлөөр, мянган хүн

Он	Улсын хилээр гарсан зорчигчид	Ажиллах	Суралцах	Байнга оршин суух	Гадаадад зорчсон Монгол жуулчид	Албан	Хувийн	Жуулчлал	Дамжин	Бусад
2018	2 460.9	418.3	26.0	16.3	1 974.3	57.0	1 776.7	131.5	0.2	8.9
2019	2 415.2	401.6	28.0	19.5	1 928.8	60.6	1 702.0	150.8	0.1	15.3
2020	571.9	293.0	6.5	3.5	263.0	25.3	217.5	17.9	-	2.3
2021	282.2	148.6	7.9	4.6	121.1	31.0	80.1	7.1	0.1	2.8
2022	728.6	184.7	21.1	93.5	429.3	70.6	267.8	83.8	0.1	7.0

Тайлбар: Жуулчин гэж байнга оршин суудаг газраас өөр газарт ажил эрхлэн, цалин, хөлс авахаас бусад зорилгоор 1 хоногоос дээш 183 хоног хүртэлх хугацаагаар аялж буй хүн буюу ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоос бусад зорилгоор хилээр гарсан зорчигчийг авч үзнэ.

* "Цахим гарц"-аар гарсан Монгол Улсын иргэдийн мэдээлэл гадаадад зорчсон зорилгоор ангилагддаггүй.

Улсын хилээр 2022 онд гарсан жуулчдыг зорилгоор нь авч үзвэл 267.8 (62.4%) мянга нь хувийн, 70.6 (16.4%) мянга нь албан ажлаар, 83.8 (19.5%) мянга нь жуулчлалаар, 7.1 (1.7%) мянга нь дамжин өнгөрөх болон бусад зорилгоор тус тус явсан байна.

ЗУРАГ 12. ГАДААДАД 2022 ОНД ЗОРЧСОН МОНГОЛ ИРГЭДИЙН ТОО, зорилгоор



Эх үүсвэр: Хил хамгаалах ерөнхий газар

2.7 ОЛОН УЛС ДАХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Дэлхийн Эдийн засгийн форумаас “Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар”-ын судалгааг 2 жил тутам зохион байгуулдаг бөгөөд “Байгаль орчны дэд бүтцийг чадавхжуулах”, “Аялал жуулчлалын дэд бүтэц”, “Аялал жуулчлалын бодлого, боломжийг бүрдүүлэх”, “Аялал жуулчлалын эрэлтийг удирдах”, “Аялал жуулчлалын тогтвортой байдал” гэсэн бүлгүүдэд хуваагдах 17 чиглэлийн нийт 112 үзүүлэлт дээр тулгуурлан дэлхийн улс орнуудыг эрэмбэлэн жагсаадаг. Тухайлбал, Бизнесийн орчин, аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуй, ариун цэвэр, хүний нөөц, хөдөлмөрийн зах зээл, харилцаа холбооны технологийн бэлэн байдал, олон улсын нээлттэй байдал, үнийн өрсөлдөөн, агаарын тээврийн дэд бүтэц, хуурай зам болон усан боомтын дэд бүтэц, аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтэц, байгалийн болон соёлын нөөц баялаг, байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт үзүүлэлтүүд ордог.


Дээрх үзүүлэлтээс Монгол Улс “аялал жуулчлалын бодлого, боломжийг бүрдүүлэх” гэсэн үзүүлэлтээр 2021 оны байдлаар 117 орноос 57 дугаар байранд, Ази, Номхон далайн орнуудаас 9 дүгээр байранд багтсан байна. Харин байгаль орчны дэд бүтцийг чадавхжуулах индексээр 66 дугаар байранд, дэд бүтцийн индексээр 106 дугаар байранд, аялал жуулчлалын эрэлтийг удирдах индексээр 61 дүгээр байранд, аялал жуулчлалын тогтвортой байдлын индексээр 103 дугаар байранд тус тус орсон нь байна.

ХҮСНЭГТ 19. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ИНДЕКС, дэд индекс

Дэд индекс	2019	2021	Өөрчлөлт
Байгаль орчны дэд бүтцийг чадавхижуулах	72	66	6 ↑
Аялал жуулчлалын бодлого, боломжийг бүрдүүлэх	28	57	-29 ↓
Дэд бүтэц	97	106	-9 ↓
Аялал жуулчлалын эрэлтийг удирдах	57	61	-4 ↓
Аялал жуулчлалын тогтвортой байдал	98	103	-5 ↓

“Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар”-ын судалгаагаар 2021 онд Монгол Улс 84 дүгээрт эрэмбэлэгдэж, 2019 оноос 9 байраар ахисан байна.

ЗУРАГ 13. ОЛОН УЛСЫН ХҮЛЭЭН АВСАН ЖУУЛЧНЫ ТОО, сая хүн, оноор



2020-2022 оны өсөлтийн хувийг 2019 онтой харьцуулсан болно.

Мэдээллийн эх үүсвэр: <https://www.unwto.org/tourism-data/global-and-regional-tourism-performance>

Дэлхийн хэмжээнд улс орнуудад хүлээн авсан жуулчны тоо 2022 онд 962.8 сая болж, өмнөх оноос 507.1 (2.1 дахин) саяар өсч, 2019 оноос 502.7 (34.3%) саяар буурсан байна.

Монгол Улс хүлээн авсан жуулчны тоогоор 113 улсаас 94 дүгээр байранд, Ази, Номхон далайн 29 улсаас 21 дүгээрт эрэмбэлэгдэж байна.



Бүлэг 3. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ



442

МЭДЭЭНД ХАМРАГДСАН
ЗЭРЭГЛЭЛТЭЙ ЗОЧИД
БУУДЛЫН ТОО



Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар



2 539

САЛБАРЫН
ААНБ-ЫН
ТОО



32 019

САЛБАРЫН
АЖИЛЛАГЧДЫН
ТОО



968.6

САЛБАРЫН
АЖИЛЛАГЧДЫН
ДУНДАЖ ЦАЛИН

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нийт орлого, тэрбум төгрөг



381.6

1022.5



Нийтийн хоолны үйлчилгээний салбар



1033

НИЙТИЙН ХООЛНЫ
ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ
ААНБ



95

БААР, ПАБНЫ
ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ
ААНБ



418

РЕСТОРАНЫ ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛДЭГ ААНБ



277

ГУАНЗНЫ ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛДЭГ ААНБ



199

КАФЕ, КОФЕ ШОП,
ЛОУНЖИЙН ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛДЭГ ААНБ



44

ЗАХИАЛГАТ ХООЛНЫ
ХҮРГЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛДЭГ ААНБ



Зочид буудал, зоогийн газрын статистикийн мэдээлэл нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед дотоод худалдааны салбарын статистикт хамрагддаг байсан байна. Жижиглэн худалдаалах бараа гүйлгээ үүнээс нийтийн хоолны бараа гүйлгээ, жижиглэн худалдааны цэг салбарын тоо, нийтийн хоолны суудлын тоог 1985 оноос нэмж гаргадаг

болжээ. Зочид буудал, зоогийн газрын салбарын мэдээлэл нь нийтийн хоолны бараа гүйлгээ гэж жижиглэн худалдаалах бараа гүйлгээнд буюу худалдааны салбарт оруулан ангилж байсныг 1990 оноос буюу зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс бие даасан салбар болж маягт, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж, сар, улирлын мэдээ, тайланг аж ахуйн нэгж байгууллагаас авч, нэгтгэн, нийтэд тархаах болсон байна. 2008 онд “Зочид буудал, зоогийн газрын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг боловсруулан гаргаж, мөрдөж байна. Энэ нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн талаарх мэдээллийг бодлого боловсруулагч, хэрэглэгчдэд хүргэх, статистикийн үзүүлэлт, ойлголт, тодорхойлолтыг нэг болгох, мэдээллийг боловсруулах, үр дүнг судалгаа, тооцоонд ашиглахад ихээхэн ач холбогдолтой болсон байна. ҮТС-ийн аргачлалын дагуу зочид буудал, зоогийн газрын салбарын нэмэгдэл, өртөг, завсрын хэрэглээ, нийт гаргалтыг тооцож эхлэн хэвшсэн байна.

3.1 САЛБАРЫН ОНЦЛОГ

Зочид буудлын үйлдвэрлэл нь аялал жуулчлал, нийтийн хоолны үйлчилгээ гэх мэт бусад үйлчилгээний салбаруудтай уялдаатай, тэр дундаа хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Зочид буудлын салбар нь хүний сайн сайхан байдал, сэтгэл ханамжид суурилсан, олон ажлын байрыг бий болгодог, удирдлагын ур чадвар, байршил, хүчин зүйлээс хамаардаг онцлог салбар юм.

Олон улсын статистик судалгааны компани “Statista”-аас мэдээлснээр дэлхийн зочид буудлын үйлдвэрлэл нь жилд дунджаар 500-570 тэрбум америк долларт хүрч байна. Өндөр зэрэглэлийн дэлхийн сүлжээ зочид буудлууд энэ салбарын стандартыг дэлхийд тодорхойлж байдаг.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын өргөжилт, эдийн засаг гадаад зах зээлд илүү чиглэх болсон зэрэг нь манай улсыг ажил хэргийн болон аяллын журмаар зорих аялагчдын тоог өсгөж, зочид буудлын үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлсэн.


Үүний үр дүнд Монгол Улсын зочид буудлын үйлчилгээний зах зээлд үндэсний томоохон буудлууд, дэлхийн дээд зэрэглэлийн буудлууд өөрийн салбаруудыг шинээр байгуулсан. Салбарын нийлүүлэлт ингэж нэмэгдсэн нь үндэсний зочид буудлуудын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, бүх талаараа олон улсын стандартад хүрэх, илүү хөгжих боломжийг бүрдүүлсэн.

Зочид буудлууд үндсэн үйл ажиллагаанаас гадна ресторан, бар, лоунж (lounge) зэргийг ажиллуулдаг. Том зочид буудлууд байгуулагдсанаар дээд зэрэглэлийн ресторонууд олноор нээгдсэн бөгөөд олон тооны оффис, үйлчилгээний зориулалттай барилга, байгууламжууд баригдаж, нийтийн хоолны үйлчилгээний нийлүүлэлтийн өсөлтөд ихээхэн түлхэц үзүүлсэн. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн технологийн дэвшлийг ашигласан үйлчилгээнүүд нь тэдний өрсөлдөөний хэрэгсэл болсоор байна.

Олон улсын статистик судалгааны компани “Statista”-аас мэдээлснээр дэлхийн зочид буудал, амралтын газрын зах зээлийн хэмжээ 2019 онд 1.5 их наяд ам.долларт хүрч дээд хэмжээндээ хүрсэн.

Харин цар тахлын (COVID-19) улмаас зочид буудал, амралтын газрын зах зээлийн хэмжээ нь 2020 онд 930 тэрбум ам. доллар болж, өмнөх оноос 38.8 хувь буюу 590 тэрбум ам.доллараар, 2021 онд 720.0 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 22.6 хувь буюу 21.0 тэрбум ам.доллараар тус тус буурчээ. Харин 2022 онд 1.06 их наяд ам.доллар болж өмнөх оноос 14.2 хувиар өсжээ.

ЗУРАГ 14. ДЭЛХИЙН ЗОЧИД БУУДАЛ, АМРАЛТЫН ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, их наяд ам.доллар



3.3 ХАМРАХ ХҮРЭЭ

ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ салбарт зочид, аялагчдыг богино хугацаанд байраар хангах үйл ажиллагааг хамруулна. Мөн оюутан, ажиллагч болон бусад хүмүүсийг урт хугацаагаар байр сууцаар хангах үйл ажиллагааг оруулна. Зөвхөн байр, сууцаар хангах төдийгүй хоол болон чөлөөт цагт зориулсан үйлчилгээг хамтад нь үзүүлж болно.

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын I дүгээр салбарын 55 дахь дэд салбар болох үйлчилгээнд хамаарах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүгдийг оруулна. Үүнд:

- 5510 - Богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагаа;
- 5520 - Автомашины зогсоол бүхий зуслан, чөлөөт цагаа өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа;

- 5590 - Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа.

НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ салбарт нийтийн хоолны газраар хийгдэх шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчилдэг, байнгын эсвэл түр ажиллагаатай уламжлалт ресторан, зоогийн газар, цайны газар, өөртөө үйлчлэх эсвэл хоолоо авч явах зориулалттай хоолны газрын үйл ажиллагааг хамруулна.

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын I дүгээр салбарын 56 дугаар дэд салбарын дараах үйл ажиллагааг оруулна. Үүнд:

- 5610 - Ресторан, хүнсний явуулын үйлчилгээ;
- 5621 - Тусгай захиалгат хоолоор үйлчлэх үйлчилгээ;
- 5629 - Хоол хүнсээр үйлчлэх бусад үйл ажиллагаа;
- 5630 - Ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа.

Статистикийн бизнес регистрийн санд 2022 оны эцсийн байдлаар нийт 86356 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 2539 буюу 2.9 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна.

ХҮСНЭГТ 20. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
БҮГД	71 716	75 522	76 329	81 533	86 356
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбарын ААНБ-ын тоо	2 199	2 249	2 222	2 266	2 539
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбарын ААНБ-ын эзлэх хувь	3.1	3.0	2.9	2.8	2.9

Улаанбаатар хотод зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбарын чиглэлээр 1647 ААНБ буюу тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 64.9 хувь, Төвийн бүсэд 343 ААНБ буюу 13.5 хувь, Хангайн бүсэд 273 ААНБ буюу 10.8 хувь, Баруун бүсэд 152 ААНБ буюу 6.0 хувь, Зүүн бүсэд 4.9 хувь буюу 124 ААНБ үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 21. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, бүсээр

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Улсын дүн	2 199	2 249	2 222	2 266	2 539
Баруун бүс	192	187	168	138	152
Хангайн бүс	272	267	250	252	273
Төвийн бүс	375	360	357	328	343
Зүүн бүс	126	137	114	109	124
Улаанбаатар	1 234	1 298	1 333	1 439	1 647

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 2114 буюу 83.3% нь 1-9 ажиллагчидтай, 260 буюу 10.2 хувь нь 10-

ХҮСНЭГТ 22. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, ажиллагчдын тооны бүлгээр

Үйл ажиллагаа явуулж буй 1-9 ажиллагчидтай ААНБ-ын эзлэх хувь өмнөх оноос 2.1 нэгж хувиар нэмэгдэж, харин 10-19 ажиллагчидтай ААНБ-ынх 1.3 нэгж хувь, 20-49 ажиллагчидтай ААНБ-ынх 0.4 нэгж хувиар, 50-аас дээш ажиллагчидтай ААНБ-ынх 0.4 хувиар түс түс буурсан байна.

Year	1-9	10-19	20-49	50 and over
2022 *	83.3	10.2	4.4	2.1
2021	81.2	11.5	4.8	2.5

Ажиллах хүчний судалгааны 2022 оны жилийн эцсийн үр дүнгээр зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 32.0 мянган хүн буюу нийт ажиллах хүчний 2.7 хувь нь ажиллаж байна.

Нийт ажиллагсадын тоо 2022 онд 1180.5 мянга хүрч, өмнөх оноос 54.9 мянга буюу 4.9 хувиар өссөн бол тус салбарт ажиллагсдын тоо 32.0 мянга болж, өмнөх оноос 5.6 мянган хүн буюу 14.9 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 23. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Нийт ажиллагчдын тоо, мянган хүн	1 253.0	1 146.2	1 162.9	1 125.6	1 180.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны салбарын ажиллагчдын тоо, мянган хүн	37.5	36.3	30.0	37.6	32.0
Салбарын ажиллагчдын эзлэх хувь	3.0	3.2	2.6	3.3	2.7

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 2022 онд ажиллаж байгаа ажиллагчдын 82.3 хувь нь эмэгтэй, 17.7 хувь нь эрэгтэй ажиллагчид байна.

Харин нийт ажиллагчдын 18.6 мянга буюу 58.0 хувь нь Улаанбаатар хотод, 6.8 мянга буюу 21.2 хувь нь Хангайн бүсэд, 2.6 мянга буюу 8.2 хувь нь Төвийн бүсэд, 2.5 мянга буюу 7.8 хувь нь Зүүн бүсэд, 1.5 мянга буюу 4.8 хувь нь Баруун бүсэд ногдож байна.


ЗУРАГ 15. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, бүсээр, дүнд эзлэх хувь



Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын сарын дундаж цалин 2022 онд 968.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 166.9 мянган төгрөг буюу 20.8 хувиар нэмэгджээ. Тус салбарт ажиллаж байгаа эрэгтэй ажиллагчид дунджаар 1007.4 мянган төгрөгийн цалин авч байгаа бол эмэгтэй ажиллагчид 972.9 мянган төгрөгийн цалинтай байна.

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллагчдын сарын дундаж цалин нь улсын дунджаас 2021 онд 477.7 мянган төгрөгөөр буюу 37.3 хувиар доогуур байсан бол 2022 онд 535.2 мянган төгрөгөөр буюу 35.6 хувиар тус тус доогуур болсон байна.

ЗУРАГ 16. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг



3.5 САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын жилд бүтээж байгаа баялаг 2022 онд 533.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 150.6 тэрбум төгрөгөөр буюу 39.3 хувиар өссөн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь 1.0 байна.

ХҮСНЭГТ 24. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ХЭМЖЭЭ, оны үнээр, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
ДНБ	32 582.6	37 839.2	37 453.3	43 555.5	53 851.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг	344.5	399.6	321.4	383.1	533.7
ДНБ-д салбарын эзлэх хувь	1.1	1.1	0.9	0.9	1.0

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын хөдөлмөрийн бүтээмж 2022 онд 10.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 3.5 сая төгрөгөөр өсжээ.

ХҮСНЭГТ 25. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, сая төгрөг

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Хөдөлмөрийн бүтээмж, сая төгрөг	8.4	9.5	8.7	7.4	10.9
Нэмэгдэл өртөг, тэрбум төгрөг	314.1	343.9	262.4	279.4	349.4
Ажиллагчид, мянган хүн	37.5	36.3	30.0	37.6	32.0

Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон нэмэгдэл өртгөөр тооцоолов.

3.6 ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Монгол Улсад 2022 оны байдлаар статистикийн мэдээнд хамрагдсан зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг 442 байгууллага байгаагаас 3 ба түүнээс дээш одтой 43, 2 одтой 24, 1 одтой буюу зэрэглэлгүй 375 буудал болон байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага байна.

ХҮСНЭГТ 26. ЗОЧИД БУУДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Бүгд	467	442	455	434	442
Зэрэглэлгүй	405	384	393	369	375
2 одтой	20	15	18	22	24
3, дээш одтой	42	43	43	43	43

Манай улсад зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг салбарт амралтын газар болон дээд зэрэглэлийн буудлууд ашиглалтад орсон хэдий ч үйл ажиллагаа явуулж эхэлсэн эхний жилүүдэд зэрэглэл тогтоодоггүй, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа нь тогтворжсоны дараа зэрэглэл тогтоодог байна. Тиймээс тэдгээр шинэ буудлуудын мэдээлэл ангилалд бүртгэгдэж байгаа нь энгийн буудлын тоо болон өрөөний тоо өсөхөд нөлөөлдөг байна.

ЗУРАГ 17. ЗОЧИД БУУДЛЫН ӨРӨӨНИЙ ТОО, буудлын төрлөөр




З ба түүнээс дээш одтой буудлын өрөөний тоо 2022 онд өмнөх оноос 31 өрөө буюу 0.9 хувиар, 2 одтой буудлын өрөөний тоо 133 өрөө буюу 26.8 хувиар, энгийн буудлын өрөөний тоо 909 өрөө буюу 16.0 хувиар тус тус өсжээ.

Нэг зочны байрлах дундаж хугацаа 2019, 2020 онуудад 1.0 хоног байсан бол 2021 онд дунджаар мөн 1.1 хоног, 2022 онд 2.5 хоног болсон байна.

Зочдын тоо 2022 онд 762.9 мянган хүн болж, өмнөх оноос 416.9 мянган хүн буюу 2.2 дахин өсжээ. Харин цар тахлаас өмнөх үе буюу 2019 оноос 219.9 мянган хүн буюу 22.4 хувиар буурчээ.

ЗУРАГ 18. ЗОЧДЫН ТОО, мянган хүн, буусан хоногийн тоо, нэг зочны дундаж байрлах хугацаа, хоногоор



ХҮСНЭГТ 27. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, ЗАРДАЛ, зочид буудлын зэрэглэлээр, тэрбум төгрөг

Зэрэглэл	2018 ¹	2019 ¹	2020 ¹	2021 ¹	2022 ¹
Бүгд	234.0	323	184.9	248.2	381.6
Зэрэглэлгүй буудал	47.2	78.1	59.0	81.2	108.1
2 одтой буудал	7.2	6.2	3.7	4.5	7.1
3, түүнээс дээш одтой буудал	179.6	238.7	122.3	162.5	266.4

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэн үндсэн үйл ажиллагаагаар ангилж, тооцов.

Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний салбарын орлого 2022 онд 381.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 133.4 тэрбум төгрөгөөр буюу 53.8 хувиар өсжээ. Үүнд, зэрэглэлгүй буудлын орлого өмнөх оноос 26.9 тэрбум төгрөг буюу 33.1 хувь, 2 одтой буудлын орлого өмнөх оноос 2.6 тэрбум төгрөг буюу 57.8 хувь, 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 103.9 тэрбум төгрөг буюу 63.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Зочид буудлын үйл ажиллагааны нийт орлогын 83.1 хувь нь Улаанбаатар хотод, 3.1 хувь нь Өвөрхангай аймагт, 2.5 хувь нь Дархан-уул аймагт ногдож, харин бусад аймгуудад 0.01-1.4 хүртэлх хувь ногдож байна.

ЗУРАГ 19. ЗОЧИД БУУДЛЫН ОРЛОГО, аймгаар, тэрбум төгрөг




Зочид буудлын үйл ажиллагааны орлогыг сараар авч үзвэл, 12 сард хамгийн их буюу жилийн нийт борлуулалтын орлогын 12.3 хувь, 11-р сард 8.6 хувь, 10-р сард 9.7 хувь, 9-р сард 9.6 хувь, 8-р сард 9.5 хувийн орлого орж байна. Харин 1, 2-р саруудад хамгийн бага буюу 5.1-6.1 хувийн орлого орж байна.

ЗУРАГ 20. ЗОЧИД БУУДЛЫН ОРЛОГО, сараар, тэрбум төгрөг, өсөлт бууралт



Нэг зочинд ногдох дундаж орлого 2022 онд 500.2 мянган төгрөг болж, 2019 оноос 171.5 (52.2%) мянган төгрөгөөр өсөж, харин өмнөх оноос 220.0 (30.6%) мянган төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 21. НЭГ ЗОЧИНД НОГДОХ ДУНДАЖ ОРЛОГО, ЗАРДАЛ, мянган төгрөг



3.7 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийтийн хоолны салбарын хүчин чадлыг тодорхойлох үзүүлэлт нь суудлын тоо юм. Суудлын тоо 2018 онд 45.1 болж өмнөх оноос 7.5 мянгаар буюу 19.0 хувиар, 2019 онд суудлын тоо 48.8 мянга болж, өмнөх оноос 3.8 мянгаар буюу 8.4 хувиар өсөж байсан бол 2020 онд 42.4 мянга болж, өмнөх оноос 6.4 мянган суудал буюу 13.1 хувиар буурсан байна. Харин 2022 онд 62.2 мянга болж, өмнөх оноос 16.3 мянгаар буюу 35.6 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 28. НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, СУУДЛЫН ТОО

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022*
Нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөг	620.7	663.0	605.0	698.6	1 022.5
Нийтийн хоолны суудлын тоо, мянган суудал	45.1	48.8	42.4	45.9	62.2

* Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэн үндсэн үйл ажиллагаагаар ангилж, тооцов

Нийтийн хоолны үйлчилгээний салбарын орлого 2022 онд 1.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 323.8 тэрбум төгрөг буюу 46.4 хувиар өсжээ. Үүнд рестораны орлого 229.3 тэрбум төгрөг буюу 55.9 хувиар, гуанзны орлого 45.4 тэрбум төгрөг буюу 48.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 29. НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГО¹, зоогийн газрын төрлөөр, тэрбум төгрөг

Төрөл	2018	2019	2020	2021	2022*
Бүгд	620.7	663.1	605.0	698.6	1 022.5
Ресторан	342.1	390.3	341.4	410.1	639.4
Кафе	39.8	51	44.3	48.9	70.9
Баар	20.6	22.5	13.9	15.2	35.9
Гуанз	52.6	65.6	85.2	93.6	139.0
Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ	165.7	133.6	120.4	130.9	137.3

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэн үндсэн үйл ажиллагаагаар ангилж, тооцов

Нийтийн хоолны салбарын 2022 оны орлогын 62.5 хувийг ресторан, 13.6 хувийг гуанз, 13.4 хувийг захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ, 6.9 хувийг кафе, 3.5 хувийг баарны төрлийн үйл ажиллагаанаас бүрдүүлсэн байна.


Нийтийн хоолны салбарын үйл ажиллагааны орлогыг аймгаар авч үзвэл нийт орлогын 87.8 хувийг Улаанбаатар хотод, 2.6 хувь нь Орхон аймагт, 2.3 хувь нь Дархан-уул аймагт, 1.8 хувь нь Өмнөговь аймагт, харин бусад аймгуудад 0.07-0.8 хүртэлх хувь нь ногдож байна.

ЗУРАГ 22. ЗООГИЙН ГАЗРЫН ОРЛОГО, аймгаар, тэрбум төгрөг



Зоогийн газрын үйл ажиллагааны орлогыг сараар авч үзвэл, 12-р сард хамгийн их буюу жилийн нийт борлуулалтын орлогын 9.7 хувь, 6-р сард 9.6 хувь, 9-р сард 9.2 хувийн орлого орж байна. Харин 1, 2-р саруудад хамгийн бага буюу 5.7-6.0 хувийн орлого орж байна. Зоогийн газрын үйл ажиллагааны борлуулалтын орлогын сарын мэдээнд 3-р сарын борлуулалтын орлого өмнөх сараасаа 36.5 хувь, 8-р сард 14.7 хувь, 4-р сард 11.5 хувь, 12-р сард 16.7 тус тус өсөж, харин 2-р сарын борлуулалтын орлого өмнөх сараасаа 4.9 хувь, 7-р сард 17.1 хувь, 10-р сард 2.2 хувь, 11-р сард 7.1 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 23. ЗООГИЙН ГАЗРЫН ОРЛОГО, 2022 он, сараар, тэрбум төгрөг, өсөлт бууралт



ДҮГНЭЛТ

Манай улсад сүүлийн жилүүдэд олон улсын стандартад нийцсэн худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны газрууд олноор бий болжээ. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 40.0 хувь нь худалдааны салбарт байна.

Худалдааны салбар нь хөдөлмөрийн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг бөгөөд улсын хэмжээнд уг салбарт 2022 онд 146.2 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 12.4 хувьтай тэнцэж байна.

Улсын дунджаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2022 онд 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 17.5 хувиар нэмэгдсэн бол худалдааны салбарынх 1.3 сая төгрөг болж, 18.3 хувиар өсжээ.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2022 онд 42.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 10.1 (31.2%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2022 онд оны үнээр 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 945.3 (23.2%) тэрбум төгрөгөөр өсч, ДНБ-ий 10.5 хувийг бүрдүүлсэн байна.

Худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж 2022 онд 2015 оны зэрэгцүүлэх үнээр 34.3 сая төгрөг болж, өмнөх оноос 7.0 (25.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг илүү гадаад зах зээл рүү чиглэх болсон нь манай улсыг ажил хэргийн болон жуулчлалын зорилгоор зорих аялагчдын тоог нэмэгдүүлж байна. Аялал жуулчлалын салбарын цар хүрээ, тэр дундаа хувиараа аялагч гадаадын иргэн болон дотоодын аялагчдын тоо жилээс жилд өсөж,

салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэж, стратегийн онцлох салбар болж байсан хэдий ч 2019-2021 онд цар тахлын улмаас тодорхой хэмжээгээр буурсан байна.

Аялал жуулчлалын салбарт 2022 онд 1.6 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд нийт ажиллагчдын 0.1 хувийг бүрдүүлж байна. Эндээс харахад, аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа ажиллагчдын тоо худалдааны болон бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй бага байна.

Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртөг 41.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 22.4 тэрбум төгрөг буюу 2.2 дахин өсч, ДНБ-ий 0.08 хувийг бүрдүүлж байна.

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 32.0 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 2.7 хувийг бүрдүүлж байна.

Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний орлого 381.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 133.4 тэрбум төгрөг буюу 53.8 хувиар, нийтийн хоолны үйлчилгээний салбарын орлого 1022.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 323.8 тэрбум төгрөг буюу 46.4 хувиар тус тус өссөн байна.

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 2022 онд 533.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 150.6 тэрбум төгрөгөөр буюу 39.3 хувиар өсөж, ДНБ-ий 1.0 хувийг бүрдүүлж байна.

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарынх хөдөлмөрийн бүтээмж 10.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.5 сая төгрөгөөр өссөн байна.

Худалдааны салбар нь Монгол Улсын эдийн засагт чухал байр суурийг эзэлсэн хэвээрээ байна.

Харин Аялал жуулчлал, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын орлого, нийт нэмэгдэл өртөг, хөдөлмөрийн бүтээмж, цалингийн түвшин нь бусад салбаруудтай харьцуулахад доогуур байна. Үүнд сүүлийн 2 жилд тохиолдсон цах тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдсон байдлын нөлөө байсаар байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ын тоо, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	23 797	25 859	27 396	28 076	29 672	33 028
Баруун бүс	2 174	2 291	2 260	2 193	2 164	2 308
Баян-Өлгий	435	483	462	425	377	361
Говь-Алтай	208	225	242	243	254	295
Завхан	436	462	432	435	421	475
Увс	466	487	514	497	520	548
Ховд	629	634	610	593	592	629
Хангайн бүс	2 213	2 288	2 301	2 283	2 301	2 419
Архангай	300	280	283	247	254	268
Баянхонгор	236	221	230	247	252	266
Булган	260	271	269	266	267	300
Өвөрхангай	292	363	382	330	299	304
Хөвсгөл	386	419	369	362	345	376
Орхон	739	734	768	831	884	905
Төвийн бүс	2 522	2 654	2 682	2 581	2 653	2 874
Дорноговь	311	356	358	268	295	341
Дундговь	184	196	192	195	199	216
Өмнөговь	433	492	557	601	667	724
Сэлэнгэ	697	703	653	574	534	555
Төв	160	165	174	167	179	186
Дархан-Уул	616	633	664	701	700	761
Говьсүмбэр	121	109	84	75	79	91
Зүүн бүс	914	922	986	950	1 013	1 132
Дорнод	386	406	452	428	439	502
Сүхбаатар	211	220	229	226	259	286
Хэнтий	317	296	305	296	315	344
Улаанбаатар	15 974	17 704	19 167	20 069	21 541	24295

ХАВСРАЛТ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2022 оноор бүс, аймаг, нийслэлээр, ажиллагчдын тооны бүлгээр

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Үүнээс:			
		1-9	10-19	20-49	50+
БҮГД	33 028	30 722	1 397	612	297
Баруун бүс	2 308	2 247	50	9	2
Баян-Өлгий	361	355	2	3	1
Говь-Алтай	295	289	6		
Завхан	475	466	7	2	
Увс	548	532	12	3	1
Ховд	629	605	23	1	
Хангайн бүс	2 419	2 318	74	23	4
Архангай	268	255	8	4	1
Баянхонгор	266	250	14	2	
Булган	300	294	5	1	
Орхон	905	881	19	4	1
Өвөрхангай	304	284	12	7	1
Хөвсгөл	376	354	16	5	1
Төвийн бүс	2 874	2 732	103	26	13
Говьсүмбэр	91	81	6	3	1
Дархан-Уул	761	723	27	9	2
Дорноговь	341	330	9	1	1
Дундговь	216	208	7	1	
Өмнөговь	724	676	30	9	9
Сэлэнгэ	555	536	16	3	
Төв	186	178	8		
Зүүн бүс	1 132	1 087	33	9	3
Дорнод	502	483	10	6	3
Сүхбаатар	286	273	12	1	
Хэнтий	344	331	11	2	
Улаанбаатар	24 295	22 338	1 137	545	275

ХАВСРАЛТ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, ажиллагчдын тооны бүлгээр, бүтцээр

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Үүнээс:				Хувь			
		1-9	10-19	20-49	50+	1-9	10-19	20-49	50+
БҮГД	33 028	30 722	1 397	612	297	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	2 308	2 247	50	9	2	7.3	3.6	1.5	0.7
Хангайн бүс	2 419	2 318	74	23	4	7.6	5.3	3.8	1.3
Төвийн бүс	2 874	2 732	103	26	13	8.9	7.4	4.2	4.4
Зүүн бүс	1 132	1 087	33	9	3	3.5	2.3	1.5	1.0
Улаанбаатар	24 295	22 338	1 137	545	275	72.7	81.4	89.0	92.6

ХАВСРАЛТ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛААР, МЯНГАН ТӨГРӨГ

Салбар	2018	2019	2020	2021	2022
Улсын дундаж	1 002.9	1 124.3	1 220.6	1 279.4	1 503.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	736.4	833.1	949.6	1 002.8	1 152.3
Уул уурхай, олборлолт	2 221.4	2 590.0	2 877.4	2 997.8	3 601.9
Боловсруулах үйлдвэрлэл	1 150.8	1 171.1	1 163.9	1 227.7	1 443.8
Цахилгаан, хий, агааржуулалт	1 403.3	1 452.0	1 558.9	1 603.3	1 815.2
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	726.8	830.2	977.1	1 019.3	1 183.6
Барилга	1 032.7	1 161.9	1 273.9	1 227.0	1 431.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	818.6	904.8	1 001.7	1 063.1	1 257.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 046.8	1 117.0	1 203.4	1 287.0	1 646.2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	621.4	691.5	730.2	801.7	968.6
Мэдээлэл, холбоо	979.0	1 086.6	1 196.8	1 317.6	1 728.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1 160.6	1 343.1	1 453.7	1 515.8	1 927.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1 022.8	1 197.7	1 378.3	1 401.4	1 743.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1 546.9	1 580.6	1 648.3	1 665.2	1 656.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	829.4	995.8	1 084.4	1 162.5	1 264.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	898.0	1 030.0	1 093.2	1 140.7	1 290.6
Боловсрол	760.2	903.3	1 013.0	1 045.2	1 211.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	800.4	940.7	1 108.6	1 277.5	1 474.6
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	624.2	738.1	844.0	873.4	971.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	809.8	910.7	1 019.1	1 098.0	1 278.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	672.9	799.3	906.8	1 042.9	1 205.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 479.9	1 778.0	1 822.7	1 994.1	4 826.3



**ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО**

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага
тойруу-44

Засгийн газрын III байр

Утас: (976-51)-261502,
1900-1212

Цахим хуудас: www.1212.mn

И-мэйл: information@nso.mn